



Долоо хоног тутмын хэвлэл  
2015 оны 09 дүгээр сарын 14  
№34 /895/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг**

1697

**Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол**

1699

**Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол**

1700

**Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай**

**Бүтэц, зохион байгуулалтын  
зардлын талаар авах зарим  
арга хэмжээний тухай**

**Аргачлал батлах тухай**



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

437.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 145	1697
438.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 146	1698
439.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 150	1698

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

440.	Бүтэц, зохион байгуулалтын зардлын талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 281	1699
441.	Аргачлал батлах тухай	Дугаар 288	1700

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 08 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 145

Улаанбаатар хот

#### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучингурав дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Перу Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Отгонбаярын Даваасамбууг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Перу Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Чулуунбаатарын Сосормааг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 08 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 146

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучингурав дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Чили Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Отгонбаярын Даваасамбууг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Чили Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Чулуунбаатарын Сосормааг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 08 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 150

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучингурав дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Колумби Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Отгонбаярын Даваасамбууг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Колумби Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Чулуунбаатарын Сосормааг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 7 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 281

Улаанбаатар  
хот

### **Бүтэц, зохион байгуулалтын зардлын талаар авах зарим арга хэмжээний тухай**

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 47.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрийн дагуу төсвийн зарим байгууллагад хийсэн бүтцийн өөрчлөлттэй холбогдон гарсан дараах зардалтай холбоотой асуудлыг 2015 оны 5 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгон эцэслэн шийдвэрлэхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж, шаардагдах хөрөнгийг 2015 оны улсын төсвийн зохих эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт, Сангийн сайд Ж.Эрдэнэбат нарт зөвшөөрсүгэй:

1.1. цалин хөлс, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын өр төлбөрийг барагдуулах;

1.2. байгууллага нь татан буугдсан, чиг үүрэг нь орон тооны хамт цомхотгогдсоны улмаас ажлаас чөлөөлөгдсөн төрийн албан хаагчдад хууль тогтоомжийн дагуу олгох нэг удаагийн тэтгэмжийн зардал;

1.3. бүтцийн өөрчлөлттэй холбогдох шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах үүрэг бүхий комисс, ажлын хэсгийн үйл ажиллагааны төсөвт тусгагдаагүй нэмэлт зардал, татан буугдсан буюу өөрчлөн байгуулагдсан байгууллагын архив, эд хогшлыг нүүлгэн шилжүүлэхэд гарсан бусад зардал.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, хуульд заасны дагуу тайлагнахыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Ч.САЙХАНБИЛЭГ**

**САНГИЙН САЙД**

**Ж.ЭРДЭНЭБАТ**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 7 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 288

Улаанбаатар  
хот

### Аргачлал батлах тухай

Хог хаягдлын тухай хуулийн 6.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хог хаягдлын норматив тогтоох аргачлалыг хавсралт ёсоор баталсугай.

2. Хог хаягдлын норматив тогтоох аргачлалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн дэмжлэгээр хангаж ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхоролд даалгасугай.

3. Хог хаягдлын норматив тогтоох аргачлалын дагуу 2015 оны III улиралд багтаан салбарын хог хаягдлын нормативыг тогтоож мөрдүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Д.Цогтбаатар, Батлан хамгаалахын сайд Ц.Цолмон, Зам, тээврийн сайд Н.Төмөрхүү, Эрүүл мэнд, спортын сайд Г.Шийлэгдамба нарт даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хог хаягдлын норматив тогтоох, төлбөр тооцох аргачлал батлах тухай” Засгийн газрын 2007 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 18 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Ч.САЙХАНБИЛЭГ**

**БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Д.ОЮУНХОРОЛ**

**Засгийн газрын 2015 оны 288 дугаар  
тогтоолын хавсралт**

### ХОГ ХАЯГДЛЫН НОРМАТИВ ТОГТООХ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү аргачлалыг хот, суурин газрын хог хаягдлын менежментийг төлөвлөх, хог хаягдлын үйлчилгээг санхүүжүүлэх, төсвийн төсөл боловсруулах, хог хаягдал гаргасны хураамж тогтоох, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ болон түүнд шаардлагатай машин техник, хогийн цэгийн хүчин чадлыг тодорхойлохтой холбоотой тооцоо хийхэд ашиглана.



1.2. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлын нормативыг энэхүү аргачлалын дагуу тогтооно.

1.3. Сум, дүүргийн Засаг дарга тухайн орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ болон айл өрхийн хэрэглээнээс гарч байгаа хог хаягдлын нормативыг батална.

1.4. Нормативын гол үзүүлэлтүүд нь хог хаягдлын хэмжээ, жин, дундаж нягтрал, хог хаягдал үүсэх хоногийн болон улирлын харилцан адилгүй коэффициентоор илэрхийлэгдэнэ.

1.5. Хог хаягдлын нормативыг 3 жил тутамд, шаардлагатай тохиолдолд түүнээс өмнө шинэчлэн тогтоож болно.

Хоёр. Айл өрхийн хог хаягдлын  
нормативыг тогтоох

2.1. Аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн хог хаягдлын нормативыг энэхүү аргачлалын дагуу тогтоож, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар хянан баталгаажуулж, хог хаягдлын мэдээллийн санд бүртгэнэ.

2.2. Айл өрхөөс гарах хог хаягдлын нормативыг тогтоохдоо амьдарч байгаа суурьшлын бүсийн онцлог, төрлөөс хамаарч дараах байдлаар ангилна:

- 2.2.1. төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон орон сууцны;
- 2.2.2. гэр хорооллын;
- 2.2.3. сумын төв, бусад суурин газрын;
- 2.2.4. төв, суурин газраас алслагдсан.

2.3. Хог хаягдлын нормативыг зуны улирал (4 дүгээр сараас 9 дүгээр сарыг дуустал) болон өвлийн улирал (10 дугаар сараас 3 дугаар сарыг дуустал)-ын онцлогийг харгалзан тогтоох бөгөөд жилийн хог хаягдлын нормативыг энэ хоёр улирлын дунджаар тооцож гаргана.

2.4. Хог хаягдлын нормативыг тогтоох судалгаанд төв, суурин газраас алслагдсан айл өрхийн 10-аас доошгүй хувь, сумын төвийн оршин суугч айл өрх, иргэдийн 5-аас доошгүй хувь, аймгийн төвд оршин суугч айл өрхийн 2-оос доошгүй хувь, нийслэл, томоохон хотуудын айл өрхийн 0,5 хүртэл хувийг тус тус хамруулна.

2.5. Хэмжилт хийхэд 0,75 м<sup>3</sup> эзлэхүүнтэй стандарт хогийн сав ашиглах бөгөөд сонгосон айл өрхөд хогийн савыг байрлуулж, хог хаягдлыг хог тээвэрлэх машинд ачихаас өмнө тэгшилж, нягтруулалгүйгээр өндөр,



өргөнийг нь хэмжиж эзлэхүүнийг тодорхойлно. Хог хаягдлын жинг тээвэрлэхээс өмнө граммын нарийвчлалтайгаар хэмжинэ.

2.6. Нэг төрлийн их хэмжээний хог хаягдлыг хэмжих тохиолдолд хог ачих хоосон машины жинг эхлэн хэмжиж, дараа нь хогтой машины жинг килограммын нарийвчлалтайгаар хэмжинэ.

2.7. Өвлийн улиралд үнсийг бусад хог хаягдлаас тусад нь цуглуулж хэмжилт хийнэ.

2.8. Хэмжилт бүрийн үр дүнг дараах маягтад өдөр бүр тэмдэглэнэ. Анхан шатны хэмжилтийн материал бэлтгэх ажлыг хэмжилт эхлэхээс өмнө гүйцэтгэнэ. Гарсан дүн нь эргэлзээтэй байвал дахин хэмжилт хийнэ.

..... он ..... сар ..... өдөр

Хэмжилт хийсэн газрын хаяг, байршил, нэр .....

Хогийн савны дугаар	Хогийн саван дахь хог хаягдлын өндөр h ( м )	Хогийн савны талбай s( м <sup>2</sup> )	Хогийн саванд байгаа хог, хаягдлын эзлэхүүн h x s (м <sup>3</sup> )	Хогийн савны хогтой байх үеийн жин a(кг )	Хогийн савны жин b ( кг )	Хогийн цэвэр жин a-b (кг)
1-н хүртэл						
Нэг өдөрт гарсан хогийн хэмжээ						

$M = n(a-b)$  бөгөөд M- нэг өдөрт гарсан хогийн хэмжээ, n- хэмжилт хийгдсэн хогийн савны тоо  
a-хогийн савны хогтой байх үеийн жин, b- Хогийн савны жин  
 $Y = q \cdot M$ ,  
Y- хэмжилт хийсэн өдрүүдэд гарсан нийт хогийн хэмжээ  
q- хэмжилт хийсэн өдрийн тоо, M- нэг өдөрт гарсан хогийн хэмжээ

2.9. Орон сууцны болон гэр хорооллын айл, өрхийн овор, хэмжээ ихтэй буюу 0.75 м<sup>3</sup>-ээс дээш эзлэхүүнтэй хог хаягдлыг нийт эзлэхүүний 5 хувиар нэмж тооцно.

2.10. Хувийн орон сууц барих, орон сууц засварлахад үүсэх хатуу хог хаягдлын нормативыг жилд 1 м<sup>2</sup> талбайд 0,01 м<sup>3</sup> хог хаягдал ногдохоор тодорхойлно.



2.11. Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, парк, цэцэрлэгийн хог хаягдлын нормативыг жилд 1 м<sup>2</sup> талбайгаас 15 кг хог хаягдал гарна гэж тооцно.

Гурав. Нэг хүнд ногдох хог хаягдлын нормативыг тогтоох

3.1. Нэг хүнд ногдох хог хаягдлын нормативыг тогтооходоо амьдарч байгаа суурьшлын бүсийн онцлог, төрлөөс хамаарч орон сууц болон гэр хорооллоор ангилах бөгөөд хог хаягдал, овор, хэмжээ ихтэй хог хаягдал, барилгын болон засварын ажлаас үүсэх хог хаягдлын хэмжээний нийлбэрийг тухайн хүн амын тоонд хуваах замаар тооцоолно.

$$V = (V1 + V2 + V3 + V4) / N$$

V- нэг хүнд ногдох хог хаягдлын норматив

V1- орон сууц (гэр хорооллоос) гарч байгаа хог хаягдлын жилийн дундаж хэмжээ

$$V1 = (Y\theta + Y3) / 2$$

Yθ- өвлийн улиралд гарах хог хаягдлын дундаж, Y3- зуны улиралд гарах хог хаягдлын дундаж, V2- үнс (орон сууцанд тооцох шаардлагагүй), V3- овор хэмжээ ихтэй хог хаягдал (нийт гарч байгаа хог хаягдлын эзлэхүүний 5 хувиар нэмж тооцно)

V4- Хувийн орон сууц барих, орон сууц засварлахад гарах хаягдал (1.0 м<sup>2</sup> талбайд 0,01 м<sup>3</sup> байхаар тооцно), N- нийт хүн амын тоо

Дөрөв. Аж ахуйн нэгж, байгууллага, салбарын хог хаягдлын нормативыг тогтоох

4.1. Салбарын болон аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын нормативыг энэхүү аргачлалын 2.5-2.11-д заасны дагуу тогтооно.

4.2. Аж ахуйн нэгж, байгууллага, салбарын хог хаягдлын нормативыг дараах нэгжээр тооцож тогтооно:

Хог хаягдлын эх үүсвэрийн төрөл	Тооцох нэгж
Нийтийн болон дотуур байр	1 иргэн
Зочид буудал, амралтын газар	1 ор
Хүүхдийн цэцэрлэг, ясли	1 хүүхэд
Их, дээд болон ерөнхий боловсролын сургууль	1 сурагч
Шинжлэх ухаан, судалгааны байгууллага	1 ажилтан
Номын сан, музей	1 ажилтан
Кино театр, соёлын төв	1 суудал
Цэнгэлдэх хүрээлэн, спортын ордон	1 суудал
Сүм, хийд болон олон нийтийн амралт зугаалгын бүсийн цэвэрлэгээний	1 м <sup>2</sup> талбай





Худалдааны төв, зах, дэлгүүрийн худалдаа, үйлчилгээний	1 м <sup>2</sup> талбай
Ресторан, бар, кафе	1 үйлчлүүлэгч
Агуулах, сав	1 м <sup>2</sup> талбай
Үсчин, ахуйн үйлчилгээний цогцолбор, гутал засвар, хувцас засвар, оёдлын цех	1 ажилтан
Албан байгууллага, ажлын өрөө	1 ажилтан
Төмөр замын буудал, авто тээврийн товчоо, нисэх онгоцны буудлын цэвэрлэгээний	1 м <sup>2</sup> талбай
Эрүүл мэндийн байгууллага	1 орны ашиглалтын фонд 1 үзлэг тутам
Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, цэцэрлэгт хүрээлэн, олон нийтийн амралт, зугаалгын бүсийн цэвэрлэгээний	1 м <sup>2</sup> талбай
Цэргийн анги нэгтгэл	1 албан хаагч
Үйлдвэрлэл	хүчин чадал, нэгж бүтээгдэхүүн
Барилгын хог хаягдал	1 м <sup>2</sup> талбай
Мал аж ахуй	тоо

4.3. Аж ахуйн нэгж, байгууллагын нэг өдөрт гаргах хог хаягдлын нормативыг энэ аргачлалын 4.2-т заасан хүснэгтэд тусгасан тооцох нэгж болон ажиллах өдрийн үржвэрийг нийт гарсан хог хаягдлын хэмжээнд хуваан тогтооно.

$V=L / (N \times A)$ ; V- нэг өдөрт гарах хог хаягдлын норматив хэмжээ;

L- жилд гарах нийт хог хаягдал; N- тооцох нэгжийн нийлбэр;

A- жилд ажиллах өдрийн тоо.

4.4. Энэхүү аргачлалаар тооцоолон гаргасан нэг жилд үүсэх хог хаягдлын хэмжээ нь тухайн объектуудад бодит байдлаар хуримтлагдсан хог хаягдлын жилийн хэмжээнээс 5 хувиас илүү зөрж болохгүй. Хэрэв тооцооны болон бодит дүн 5 болон түүнээс дээш хувиар зөрсөн тохиолдолд нормативыг шинэчлэн тогтооно.

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiin\_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.5

Индекс: 14003